



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 105

Номгон

“Баянхонгор робокон” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор робокон” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117253

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 17-ны
өдрийн 105 дугаар тогтоолын хавсралт



“БАЯНХОНГОР РОБОКОН” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Ямар нэг үйлдэл гүйцэтгэдэг роботыг бүтээнэ гэдэг нь электроник, програмчлалын ач холбогдлыг сурагчдад ойлгуулах, мэдүүлэх маш сонирхолтой арга зам юм. Хар цагаан өнгө мэдэрч даалгавар гүйцэтгэх робот дэлхийн дахинд эрчимтэй хөгжиж олон хүүхэд залуучууд түүгээр хичээллэж байна. Төрөл бүрийн робот бүтээнэ гэдэг зөвхөн мэргэжлийн хүмүүсийн хийдэг ажил байхаа нэгэнт больсон.

Баянхонгор аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.16 заалтад Авьяас хөтөлбөрийг үргэлжлүүлэн хүүхдийн техник сэтгэлгээ, оюун ухааныг хөгжүүлэх “Өсвөрийн зохион бүтээгч клуб”-ыг сургууль бүрт байгуулж, “Робокон-Баянхонгор” тэмцээнийг жил бүр зохион байгуулна гэж заасан.

ХОЁР. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өнөөдөр хүн бүрийн хэрэглээ болсон гар утас, компьютер, янз бүрийн ухаалаг төхөөрөмжүүд нь роботикс гэдэг технологийн хөгжлийн үр дүн гэж үзэж болох юм. Технологийн хөгжлийн өдөөгч гол хүчин зүйл нь хүний үйл ажиллагааны хязгаарлагдмал хүч, чадварыг орлохуйц техник төхөөрөмжийг бүтээх гэсэн оролдлого бөгөөд олон улсын хэмжээнд робот тоглоом, програмчлагддаг ухаалаг төхөөрөмжүүдийг сургалтад нэвтрүүлэн ашиглаж байна. Үүнтэй холбоотойгоор роботын олон уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсаар ирсэн бөгөөд манай улсад гэхэд “ABU робокон”, “RobotSumo”, “Мон робот”, “Автомат робот” уралдааныг жил бүр зохион байгуулсаар байна. Энэ чиглэлээр хүүхэд залуусыг хөгжүүлж тэмцээн уралдаан зохиох, оролцуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Аймгийн ЕБС-иудад хичээл сургалтаас гадуур нисэх, авто, усан загвар, легоробот, цагаан шугам дагаж үйлдэл гүйцэтгэх робот бүтээх сургалт, дугуйлангууд хичээллэж, техник технологийн хөгжлийн суурийг тавьж эхэлсэн нь хонгор нутгийн хүүхэд залуус дэвшилтэт технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах үндэс суурь болж байна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Сурагчдад техник, электроник, технологийн боловсрол олгох, цагаан зураас мэдрэгч робот бүтээх, хөгжүүлэх

Зорилт 1. Сургалт явуулах багшлах боловсон хүчин бэлтгэх

Зорилт 2. Сурагчдад электроникийн боловсрол олгох, робот бүтээх, програмчлах, хөгжүүлэх сургалт явуулах

Зорилт 3. Электроник, роботын сургалт явуулах орчин бүрдүүлэх

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /2017-2018 онд хийгдэх ажил/

Төслийн зорилт	Үндсэн үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Төсөв, санхүүжилт	Үр дүн /шалгуур үзүүлэлт/
Зорилт 1: Сургалт явуулах багшлах боловсон хүчин бэлтгэх	1. Сургууль бүрт “Өсвөрийн зохион бүтээгч” хичээллүүлэх багш нарын баг байгуулах /физик, мэдээлэл зүй, технологийн багш/ 2. Өсвөрийн зохион бүтээгч клуб хичээллүүлэх багш нарын сургалт зохион байгуулах	1.ЕБС-ийн захирал удирдлагууд 2.БСУГ, ЕБС, “Зөгий3” сургалтын төв	Нэг оролцогчийн сургалтын төлбөр 235.000 төгрөгийг тухайн сургууль хариуцах Сургалтад оролцогчдын цайны зардал 500.000 аймгийн Засаг даргын санхүүжилтээр	“Өсвөрийн зохион бүтээгч” клуб хичээллүүлэх багш бэлтгэгдсэн байна /25 сургууль/
Зорилт 2: Сурагчдад робот техникийн технологийн боловсрол олгох сургалт явуулах	1. Робот бүтээх хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх <ul style="list-style-type: none"> • Техник • Технологи • Робот • Си хэл, програмчлал 2. Цагаан зураас бүхий тэмцээний талбайг янз бүрийн өгөгдлөөр өөрчилж программ бичих, турших аргыг эзэмшүүлэх 3. Роботын хурд, хүчин чадал, найдвартай ажиллагаа зэргийг сайжруулах арга замд бүтээлч эрэл хайгуул хийх 4. Клубын үйл ажиллагаанд зөвлөн туслах 5. “Баянхонгор-робокон” тэмцээнийг 2020 хүртэл жил бүр зохион байгуулах а.Цагаан зураас дагах хурдны б.Цагаан зураас дагаж даалгавар гүйцэтгэх в.Удирдлагатай механик робот	Клубын багш нар БСУГ, “Зөгий3” сургалтын төв Аймгийн ЗДТГ, БСУГ	Аймгийн Засаг даргын санхүүжилтээр	Клубын сурагчид робот бүтээж хөгжүүлэх мэдлэг чадвар эзэмшсэнээр Клуб бүрд зөвлөн туслах, хүрч ажилласнаар Тэмцээн зохион байгуулагдсанаар

Зорилт 3: Электроник, роботын сургалт явуулах орчин бүрдүүлэх.	1. "Өсвөрийн зохион бүтээгч" клуб байгуулах журам боловсруулна. 2. Сургалтын бие даасан клуб байгуулах 3. Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах <ul style="list-style-type: none"> • Робот кит /3-5 иж бүрдэл/ • Гар багаж /3-5 ш/ • Цахилгаан багаж /1-2 ш/ Гар болон алсын удирдлагатай механик роботын бүрдэл	БСУГ ЕБС	2017 онд Робот китний 300.000-500.000, багажны 150.000 төгрөгийг Баянхонгор сумын сургуулиуд өөрсдөө, хөдөөгийн сургуульд сумын ЗДТГ-ын санхүүжилтээр 2018 онд 500.000 төгрөг хөдөөд сумын ЗДТГ, Баянхонгор сумын сургуулиуд өөрсдөө	Журам боловсруулж баталгаажуулсан байна. Суурь бүрэн дунд сургуульд клуб байгуулагдаж сургалтын үйл ажиллагаа явуулснаар Сурагчид робот бүтээх хэрэглэгдэхүүнээр хангагдсанаар
--	--	-----------------	--	---

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

5.1. Улсын төсөв

5.2. Орон нутгийн төсөв

5.3. Иргэд, аж ахуй нэгж байгууллагын санаачлагаар өгөх тусламж.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

2017 онд 5 сая төгрөг

2018 онд 5 сая төгрөг /радио удирдлагатай механик робот хөгжүүлэх/

2019 онд 5 сая төгрөг

2020 онд 5 сая төгрөг

ДОЛОО. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэгт аймаг сумын Засаг даргын Тамгын газар, ЕБС-ийн багш удирдлага, иргэдийн төлөөллийг оролцуулсан байна.

7.2. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, үр дүн, шалгуур үзүүлэлтийн хангагдсан байдал, удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилт, үйл ажиллагаанд хэрхэн дэмжлэг болж чадсаныг судлахад оршино.

НАЙМ. ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭЛБЭР, ҮЕ ШАТ

8.1 "Баянхонгор-Робокон" аймгийн дэд хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн явцад төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрд үнэлгээ хийнэ. Үүнд:

1-р үе шат буюу 2017-2018 он

2-р үе шат буюу 2019-2020 он

8.2 Явцын үнэлгээг 2 жил тутамд зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.



_____оОо_____